

ARTICLE

Баргын уламжлалт соёлыг ардын дуугаар мөшгөн судлах нь

Гэмпилийн СЭЦЭН\*

Монголын Улс, Улаанбаатар,

Соёл Урлагийн Их Сургууль,

Хөгжмийн урлагийн сургууль,

Email: [Sqin3026@126.com](mailto:Sqin3026@126.com),

<https://orcid.org/0009-0000-8728-3602>

Дэлгэрхүүгийн НАРАНЦАЦРАЛ\*\*

Монгол Улс, Улаанбаатар,

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль,

Нийгэм хүмүүнлэгийн сургууль,

Түүх, соёл, аялал жуулчлалын тэнхим

Email: [narantsatsral5@gmail.com](mailto:narantsatsral5@gmail.com),

<https://orcid.org/0000-0002-6493-8685>

**Received:** December 01, 2025 | **Accepted:** December 13, 2025 | **Published:** December 30, 2025

*Хураангуй:* Хөлөнбуйрын баргууд оюун билиг, уран сэтгэмж, ур чадвар авьяасаараа олон арван дуу зохиосон. Үүнд ойн иргэдийн үеийн дуу болон ой хөвчөөс гарч тал нутагт нутаглах болсон үеийн дуу багтана. Гэхдээ малчин болсноос хойших дуу нь өргөн дэлгэрч ирсэн. Эдгээр барга дууны цуурайлаг, уянгалаг, уужуу өргөн цараа нь тал нутгийн дууны шинжийг хадгалсан байх ба бусдаас ялгарах гол онцлог нь болно. Монгол ардын дуунаас Барга дууны ялгаатай тал нь нутгийн аман аялгуу болоод ая аялгуунд оришино. Ардын дуу бол үг ая хоёроос бүрэлдсэн нэгдмэл цогц мөн. Өөрөөр хэлбэл хэл зүй болон хөгжмийн урлаг хоёрын нэгдсэн хэлбэр болох юм. Ардын дуу нь дуулаачаас дуулахуйн ур чадварыг шаардах төдийгүй тухайн дууг хэрхэн амьдруулж, ард түмний сонорт хүргэх нь чухал.

\* © Г.Сэцэн, 2025; Холбоо барих зохиогч

\*\* © Д.Наранцацрал, 2025

Өнөр баян нутагтаа үе улиран амьдарч ирсэн Баргууд урт удаан түүхийн явцдаа үлэмж олон дууг зохион дуулж уламжлан дэлгэрүүлж, залгамжлан хөгжүүлж ирсэн юм. "Ардын дуу бол түүний зохиогчид болох ард түмэнтэйгээ хамтаар урт удаан түүхтэй байж, тэдний амьдрал тэмцлийг тал бүрээс нь тусгасан байдаг. Баргын түүх соёлыг ардын дуугаар дамжуулан судалж буй тул энэхүү өгүүллийг бичлээ.

Баргуудын түүхэн хөгжил, зан заншил, газар зүйн байришил, шашин шүтлэг, уламжлалт аман соёл, түүнчлэн барга ардын дууг цуглуулж, хөгжмийн шинжилгээ хийсэн.

Барга дуунд баргуудын мал аж ахуй эрхлэх байдал, түүхэн үйл явдал, түүхт хүмүүс, шашин шүтлэг, үзэл баримтлал, хурим найрыг багтаасан зан үйлийн олон талыг тусгасан төдийгүй баргуудын нутаг усаа хайрлаж, настан дээдсээ хүндэлж, үр хүүхдээ энхрийлэн энх амгаланг хүсээж, бүгдээр жаргахыг эрмэлздэг эрхэм дээд сэтгэлгээ нь дууны үгээр илэрч байдаг. Тэрчлэн гүн ухааны буюу жам ёсны тухай өгүүлсэн дуу байх бөгөөд мөн эрдэм сурахыг чухалчилсан дуу ч байдаг. Баргын түүх соёлыг ардын дуугаар дамжуулан судалж буй тул энэхүү өгүүллийг бичлээ.

**Түлхүүр үг:** Цагаалах, хүндлэх, тахилга, аман соёл, хурим найр, ардын дуу

## **A Folklore-based Study of Barga Traditional Culture**

*SEQIN, G*

*School of Music Art,  
Mongolian National University of Arts and Culture,  
Ulaanbaatar, Mongolia*

*NARANTSATSRAL, D*

*Department of History, Culture, and Tourism  
School of Social Sciences and Humanities,  
Mongolian University of Science and Technology,  
Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** *The Barga's of Hulunbuir have composed dozens of songs with their intellect, imagination, skill, and talent. These include songs from the era of forest dwellers and songs from the time when they moved from the forest to the plains. However, the songs from after they became herders have become more widespread. The echoing, melodious, and spacious nature of these Barga songs preserves the characteristics of plains songs and is their main distinguishing feature. The difference between Barga songs and Mongolian folk songs lies in the local dialect and melody. A folk song is a unified whole composed of words and melody. In other words, it is a unified form of linguistics and musical art. A folk song not only requires singing skills from the singer but also how to bring the song to life and deliver it to the people.*

*The Barga's, who have lived in their prosperous homeland for generations, have composed, sung, inherited, spread, and developed many songs over their long history. "A folk song has a long history together with its creators, the people, and*

*reflects their life and struggle from all sides. This article was written to study the history and culture of Bargy through folk songs.*

**Keywords:** *Respect, sacrifice, oral culture, weddings, folk songs*

## Удиртгал

Барга нутаг бол өргөн уудам тал хөндийтэй, сүрлэг уул хайрхантай, тунгалаг гол мөрөнтэй нутаг билээ. Хүн ард нь ч сүүн цайлган сэтгэлтэй, удам угсаа сайтай, цээл тунгалаг хоолойтой, уянгаг сайхан ардын дуутай билээ. Барга дуу болох “Саруул тал”, “Мөнтгөр саарал”, “Үхэрт хүйтэн”, “Эр бор харцага”, “Соёг бор”, “Бор бор бялзуухай” гэх мэт олон сайхан дуунууд нь уламжлагдан өвлөгдөж, өнөөдрийг хүртэл ард олны дунд дэлгэрэн хөгжиж ирсэн.

Хөлөнбуйрын баргууд оюун билиг, уран сэтгэмж, ур чадвар, авьяасаараа олон арван дуу зохиов. Үүнд ойн иргэдийн үеийн дуу болон ой хөвчөөс гарч тал нутагт нутаглах болсон үеийн дуу багтана. Гэхдээ малчин болсноос хойших дуу нь өргөн дэлгэрч ирсэн байна. Эдгээр барга дууны цуурайлаг, уянгалаг, уужуу өргөн цараа нь тал нутгийн дууны шинжийг хадгалсан байх бөгөөд бусдаас ялгарах гол онцлог нь болно.

## I. Баргын уламжлалт утга соёл

**Цагаалах заншил.** Чин улсын сүүлчийн үе буюу манжийн үед баргуудын цагаалах зан үйл нь орон нутгийн өвөрмөц онцлогтой, төрийн ёслол болон шашны ажиллагааг багтааж байсан өргөн ойлголт бүхий заншил юм. Шинэлэхээс өмнө айл гэр бүхэн цагаан сард өмсөх шинэ арьсан дээл оёх, шинэ малгай, бүс, гутал зэргийг бэлтгэж цагаан сард хэрэглэх хөх торгон хадаг, цагаан хадаг архи, амттан, элдэв боов боорцог мэтийг худалдан авч бэлтгэдэг. Цагаалахад унаж давхих морьдоо сойж, эмээл хазаараа шинэчлэх ажлыг идэр насны залуучууд хийж гүйцэтгэнэ. Шинэ бууцанд буусны дараа цагаан сараа тэмдэглэдэг.

Баргууд нь цагаан сараар бүх төрөл саднаараа золгон найрлаж, ахмад настнаа хүндэтгэсэн дуу, сургаал дуу, найр хуримын дууг дуулж, бүхэл жилдээ энх амгалан сайн, сайхан байхыг бэлгэддэг. Жишээлбэл, “Аавын сургаал ээжийн хайр”, “Эрдэнэ уулын бараа”, “Замбуулин хорвоо ертөнц” зэрэг дууг дуулдаг.

**Аав ээж, ахмад настнаа ачилж хүндэлдэг заншил.** Баргуудын аж амьдрал, соёл, хүмүүжил, ёс суртахуунтай холбоотойгоор болж гэрийн ахмадууд болон үр хүүхдүүдийн хооронд элэгсэг дотно хайр сэтгэл, элбэрэл журам, өршөөл ачлалын харьцаа бий болсон байдаг. Эмээ өвөө, аав ээж нар нь үр ач нараа “алтан ясны хэлтэрхий, алаг махны тасархай” хэмээн энхрийлэн хайрлах бөгөөд “хөрөнгийг нь залгамжилж, алдар хүндийг минь бадруулж явах хүн, өтөлж доройтоход минь асран сувилах юм” гэж үзэн, нялх нярайгаас нь өсөж томортол нь хайрлан халамжилдаг тул хүүхэд ач нар нь ч өвөө эмээ ба эцэг эхдээ хайртай байдаг (Сэцэн, Наранцацрал, 2025). Хүүхдүүд, үр ач нар нь “үнэнч хайраараа өсгөж бойжуулан” хүний зэрэгт хүргэсэн хүндэт ачтан” гэж үздэг болохоор гэрийн ахмад настандаа тусалдаг. Охин хүүхэд бол эмээ, ээждээ туслан, аргал хоргол зөөх, ус оруулан цас хайлах, үнээ ивэлгэх, тугал хариулах зэрэг ажил

хийдэг. Хүү хүүхэд бол өвөө, аавдаа морийг нь барьж, эмээлийг нь тохож өгөх, морьтой ирвэл морины эмээлийг нь авч, чөдөрлөн тавих, үхэр хураах, хонь буцаах зэргээр тусалдаг. Томроод ирэхээрээ аав ээжийнхээ хийдэг ажлыг орлон хийж, гэрийн хүнд ажлуудыг хийж гүйцэтгээд, аав ээжээ амраадаг.

“Гархилан урсах хандгайн гол” богино дуу нь аз жаргалыг ивээн, баяр жаргалыг хүртсэн аав ээж, ахмад настныхаа алтан сургаалаар эрүүл энх байхыг бэлгэдсэн дуу болно. “Жаран цагаан тэмээ” гэдэг бэсрэг уртын дуу нь эхийн хайр, үрийн сэтгэл буюу эх үрийн харьцааг илэрхийлсэн агуулгатай. Энэ нь Хорчин дуу “Өнчин цагаан тэмээ” гэдэг бэсрэг уртын дуутай төстэй

**Уул овооны тахилга.** Баргууд газар орноо эцэг тэнгэр, эх дэлхий гэж хүндэтгэн хайрладаг. Эх орон, төрж өссөн нутаг усаа хайрлан хүндэтгэх сэтгэлээр аймаг, хошуу, сум, овог, айл өрхөөрөө овоо босгон тахидаг байв. Баргууд 1734 онд Хөлөнбуйрт ирж суугаад, 1740 оноос Мэнэнгийн Богд уулыг шинэ барга баруун хошуугаараа олон овоо босгон тахижээ. Уул овооны тахилгыг сар өдөр тогтоон жил бүр хийдэг. Уул овооны тахилгадаа (эрийн гурван наадам, морь уралдах, бөх барилдах, түнх харвах) тахилгын найр хийж, уул овоо, орон дэлхийгээ хүндэтгэн шүтэх сэтгэлээ илэрхийлдэг. Уул овооны тахилгад эд мөнгө, идээ будаа бэлтгэн, даллага тахил тавьдаг. Хуучин уул овооны жасын мал хөрөнгө ч арвин байжээ. Одоо бол сэргээн тахиж байх уул овоонд сумын овоо 17, өвийн овоо 2, халын овоо 7, айлын овоо 6, суварга 1, нийт 34 уул овоо тахиж байна.

Уул усаа магтсан “Баргын гурван богд уул”, “Гархилан урсах Хандгайн гол”, “Далайн хойдох ооржин уул”, “Могой шинжийн Оршуун” зэрэг дуунууд бий.

**Шашин шүтлэг.** Шинэ баргууд бүх монголчуудтай адил бөө мөргөлтэй байснаа шинэ баргууд 1734 он буюу Чин Улсын Найралт төвийн 12-р онд халхын цэцэн хан аймгийн Жанчивдоржийн хошуунаас Хөлөнбуйрт нүүж ирэх үедээ шарын шашныг шүтэж, бурхан номыг Төвөдөөс залж сүм хийд байгуулж, шашин шүтлэгийг ихэд дэлгэрүүлсэн юм. Хөлөнбуйрт ирж нутагласнаас хойш уул овоо тахиж, сүм хийд байгуулан, олон лам нартай болж, цаг хугацаатайгаар улирал урины хурал номоо хурж, сүм хийдийн жас захиргаа, зэрэг хэргэмийг бий болгож байв. Нийгмийн хөгжлийг даган бурхан шашин нь ч мандах, доройтох, дахин сэргэсээр эдүгээ хүрч байна. 1780-аад оны үед барга найман хошуунд нэг л Ганжуур сүмтэй байснаа өргөжиж, хошууны сүм, сумын сүм зэрэг 46 сүм хийд байгуулжээ. Бурхан шашны үйл ажиллагаа нь хурал номоо хурж, уул овооны тахилгаа үргэлжлүүлж байна.

1917 онд шинэ баргууд тухайн үеийн нийгмийн байдлаас болж, халхын нутгаас дүрвэж нүүгээд, 1925 онд эргэж ирсэн. Энэ байдлаас болж баруун гарын 4 хошууны сүм хийдээ нүүлгэн шилжүүлж ч байв. Өдгөө залуу лам нар ном мэдлэгтэй цагаарсан тул засаг захиргааны зүгээс хүндэтгэж, 2012 онд шинэ сүм хийд нэмж байгуулжээ. Тухайлбал: Ганжуурын сүм нь аймгийн хэмжээний үндэсний онцлогтой найр наадам хийдэг байсан ба 1948 оноос эхлэн аймгийн наадам гэж нэрлэх болж, жил бүр 8 буюу 9 дүгээр сард аймгийн захиргаанаас эрхлэн явуулсаар 1962 он болтол үргэлжилжээ. Ганжуур наадамд үндэсний биеийн тамирын тусгай чуулгынхан хүртэл оролцож өргөжүүлээд, сүүлийн үед ӨМӨЗО-ны нам засгийн хариуцлагатнаас эхлэн уран сайхны бүлгэм, цэргийн морин мэргэжлийн бүлгэм, Монгол Улсын урлагийн бүлгэм тусгайлан уригдан

ирж оролцдог болсон. Улс байгуулагдсаны дараа нам засгаас Ганжуур сүмийн түүхэн байр суурь нөлөөг үндэслэж, улсын дэсийн түүх соёлын газар ба ӨМӨЗО-ы дэсийн түүх соёлын газраар тогтоож, хамгаалсан байна.

Шашин шүтлэгийн агуулгатай “Анжааны лам”, “Чингүнжэ”, “Жирвэс жирвэс” зэрэг дуунд нь лам нарын бодит амьдралыг өгүүлсэн байдаг.

### Уламжлалт аман соёл

1. Ерөөл бол баргуудын сайн сайхныг бэлгэдэж, ах дүү, үр хүүхдэдээ хүсэл эрмэлзлээ найдаж байгаагаа илтгэж байгаа зөгнөл юм. Баргуудын ерөөлд урт насалж удаан жарга, үр хүүхдээр өнөр баян, хөрөнгө мал дүүрэн баян, өв соёлоо уламжлан залгамжилж, нэр төрөө мандуулж явах хүсэл эрмэлзэл голлодог.
2. *Сургаал үг.* Баргуудад хойч үеийн хүүхдээ сурган хүмүүжүүлэхэд зориулагдсан сургаал үг байдаг. Сургаал үгийн дотор хичээж болгоомжлох, ажил үйлсийг дээшлүүлэх зорилгоор хэлж сургах, хийж дагуулах, мэдрүүлж засах, үнэлж зоригжуулах, төв голч үзлийг баримтлах зэрэг олон сургаал үг байжээ.
3. *Цээр ёсон.* Баргууд эрт дээр үеэсээ олон талын ажил хэрэг, үйл явдалд хичээж цээрлэх зүйлсээ цээр болгон журамлаж хэрэгжүүлсээр ирсэн.
4. *Онъсого таалцах.* Баргуудад олон онъсого байдаг. Жишээлбэл, Ариунаас ариун арван хоёр нүхтэй тэр юу вэ? -Энэ бол бойпор гэх мэтчилэн олон онъсого байдаг.
5. *Зүйр цэцэн үг.* Жишээлбэл, Эрдмийг олбол ичгүүрийг сана! Жаргалыг олбол зүдүүрийг сана!, Эдийн сайн нь гаднаа хүний сайн нь дотроо гэх мэт.
6. *Аман зохиол.* Жишээлбэл, Эрхий мэргэн баатрын тухай: Эрт урьдын цагт эрхий мэргэн баатар Эрдэнэ гуа ах нартайгаа байсан гэх мэтээр шүлэглэн бичдэг байжээ.

Уламжлалт аман соёлд ардын аман үлгэр, зүйр цэцэн үг, онъсого таалцах зэрэг уламжлалт соёлууд өдгөө бидэнд уламжлагдан хадгалагдаж ирсэн.

### II. Хуримын дууны судалгаа

Ураг худын ёс нь эртний уламжлалтай нарийн дэг журам, зан үйлтэй аж. Баргуудын дунд өрх гэр үүсгэхийг төрийн хэрэг “өрх өсгөж, сум сунгах” хэмээн хүндэтгэж ирсэн нь хүмүүжлийн ач холбогдлыг агуулдаг ба аливаа юмны барилдлага, бэлгэ дэмбэрлийг эрхэмлэн дээдлэх амьдралын хэвшил болжээ. Айлын гал голомтын эзэн, өрхийн толгойлогч эр хүн байх уламжлал бол эцэг талаар удмаа үргэлжлүүлэхийн эх үндэс юм. Иймд хүүтэй айл ором (гэр орон) төхөөрч, бэр сонгож гал голомтоо сахиулах ёстой. Хэд хэдэн хөвгүүдтэй бол тэд айл гэр болон тасарч, отгон хүү нь гол төлөв эцгийн голомтонд үлдэх ёстой гэж үздэг байжээ.

Ардын дууны шинжилгээ судалгаанд найрын дуу ба хуримын дууг хамтатгаад хурим найрын дуу гэж хэлдэг. Гэвч найрын дуу, хуримын дуу нь ялгаатай. Энэхүү өгүүлэлд барга хурим найрт дуулагддаг хуримын дууны тухай судлан шинжилсэн болно. Найрын дуу ба хуримын дуу нь бас ялгаатай. Монгол хэлэнд хурим найр

гэх үг нь хоёрдмол утгатай. Баяр найр хийхийг хурим найр талбих гэж хоршин хэлдэг бөгөөд хуримлах найрыг бас хурим хийх, хурим талбих гэх мэтээр хэлдэг уламжлалтай байжээ. Барга найрын дуу ба хуримын дуу нь барга ардын дуунд нэлээд голлох байр суурийг эзэлдэг. Барга хурим найрын дуунд бэсрэг уртын дуу нэлээд хэсгийг эзэлж байдаг. Тус дуунуудад Хөлөнбуйрын түгээмэл онцлог шинж болох илтгэх хэв маяг, хэлбэр байдал, ая хөгийн өвөрмөц өнгө ялгарал зэрэг нь тодорч байна.

Барга хуримын үед “Алтай хангайн даваа”, “Нарийхан халиун”, “Соёг бор”, “Алтан товруутай зодог”, “Баян баргын манаа”, “Эр бор харцага” зэрэг дууг дуулж хурим найраа эхлүүлдэг. “Мөнтгөр саарал” гэх ардын дуу нь хурим найрт маш өргөнөөр дуулагддаг.

Хөлөнбуйрын барга хуримын уртын дуу нь үе дамжин хөгжсөөр өөрийн гэсэн хэв намбатай болжээ. Нарийн гоё нугалаа чимэглэлтэй, хаялга цацлага ихтэй, төвөнх хоолойн цохилготой, дууны эхлэл чимэг ихтэйгээс гадна дуугаа ихэвчлэн хаялгаар төгсгөдөг. Цараа хүрээний хувьд Төв халхын уртын дуу шиг өргөн биш аялгуутай, өөрөөр хэлбэл бэсрэг уртын дуу байдгаараа онцлогтой.

Барга хуримд “Бүрэн хадын бургас”, “Алтай хангай”, “Эрдэнэ уулын бараа”, “Эр бор харцага”, “Саруул тал”, “Нарны тунгалаг”, “Нарийхан халиун”, “Алтан товруутай зодог”, “Соёг бор”, “Замбуулин хорвоо ертөнц”, “Алтай хангайн даваа”, “Цагаан саарал”, “Баян баргын манаа” зэрэг олон дууг дуулдаг байжээ. Эдгээр дуунууд нь барга найр, барга хуримд түгээмэл дуулагдаж ирсэн бөгөөд барга дуунд чухал байр суурийг эзэлж байгааг доорх судалгаагаар нотолж байгаа юм. “Замбуулин хорвоо ертөнц” гэх барга бэсрэг уртын дуу бол барга хуримд өргөн дуулагдаж байсан дуу мөн. “Замбуулин хорвоо ертөнц” дууны хэсгээс

“Замбуулин хорвоо ертөнц  
Зайлшгүй дөрвөн далайтай  
Залуу багахан насанд  
Жаахныг дагах л хэрэгтэй  
Гэгээн нарантай замбуулин  
Гэтэлшгүй дөрвөн далайтай  
Гэнэн бага л насандаа  
Хичээмтгий явах л хэрэгтэй...”

(Монгол ардын дууны чуулган, 1992: 361) гэж дуулдаг 4 бадагт уртын дуу болно. “Замбуулин хорвоо ертөнц” гэх Барга бэсрэг уртын дуунд хорвоо ертөнцийн



жамаар өсөж бойжих залуу бага насанд ч сэтгэл санаа, ухаан бодол хийгээд, зол жаргалын хоорондох харьцааг зүйлчлэн тусгасан, гүн ухааны утга агуулгатай дуу болно.

Зураг 1. “Замбуулин хорвоо ертөнц” дууны үгтэй ноот

Баргын уламжлалт хуримд “Эрдэнэ уулын бараа” гэх бэсрэг уртын дуу өргөн дуулагдаж байв. Барга дуунд “Эрдэнэ уулын бараа” гэх уртын дуу

шиг олон бадгаар дуулагдаж байсан уртын дуу нэлээд цөөхөн. Дуучин Нацагдорж

дуулсан “Эрдэнэ уулын бараа” бэсрэг уртын дууны барга хувилбар нь мөн л хагас түрлэг. Нооттой хавсарган арван дөрвөн бадаг шүлэг тэмдэглэгдсэн ба шүлгийн агуулга, эх нутаг, аав ээжээ санасан “тунирхах” аястай дуу юм:

“Эрдэнэ уулын бараа” дууны хэсгээс

“Эрдэнэ уулын бараа  
Эрхэм тодорхой харагдана  
Ийм л ойрхон суухад  
Эргэж буух нь яана вэ  
Салаа салбар модонд  
Сайхан дуутай гургалдай  
Салаад сөргөө харахад  
Миний ээж хөөрхий  
Мод л модны дундаас

Мойлын иш нь илэрхий  
Мордоод сөргөө харахад  
Миний л ээж хөөрхий  
Элэгдэхийн түрүүнд  
Энгэр тохой хоёр  
Энэрэхийн түрүүнд  
Ээж аав хоёр”... (Монгол ардын  
дууны чуулган, 1992: 492)

гэж дуулдаг 18 бадагтай уртын дуу болно. Энэ мэтчилэн цаашид барга хуримын дуу ба барга найрын дууг ноотлон бичиж, өв уламжлалыг хамгаалах, хадгалж үлдээх, хойч үедээ үлдээх нь бидний үүрэг болно.

Барга дуунд гүн агуулга бүхий үр хүүхдээ сургамжилсан үг хэллэг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал:

#### Бүүвэйн дуу

Баян Баргын бүүвэлдэй  
Бүүвэй бүүвэй бүүвэй  
Барын арьсан манцуйтай  
Баатар жанжин удамтай  
Бүүвэй бүүвэй бүүвэй  
Манцуйтайхан байхад  
Манай үр нь гэнэ  
Охиноо хүнд өгөх үед:

Магнаг торгоор чимэхээр  
Хүний л үр боллоо  
Өлгийтэйхэн байхад  
Өөрийн үр л гэнэ  
Өнгийн торгоор чимэхээр  
Хүний үр л боллоо

#### Үндгэн хуар

Ууланд ургаагүй угалзан хуар  
Усанд унаагүй үндгэн хуар  
Урьхан жаахан үрийгээ  
Хаданд байдаггүй харгуй хуар  
Хальс унаагүй үндгэн хуар  
Хайртай жаахан үрийгээ

Хааны журмыг түшүүлэй  
Ногттойхон морины  
Ашгийг нь бодож аваагүй  
Лонхтойхон архины  
Бэлгийг нь бодож авлай

#### Найман цагаан хүлиэ (Мөнтгөр саарал)

Найман цагаан хүлиэгээ (эд бараа хийдэг битүү чингэлэг)  
Нарыг нь дагуулж гинжиллээ дээ (угсарлаа даа)  
Найман ханатай гэртээ  
Найрлаж суугаад мордлоо доо  
Долоон цагаан хүлиэгээ  
Довыг нь дагуулж гинжлээ дээ  
Долоон ханатай гэртээ  
Доролж (ёсолж найрлах) наадаад мордлоо доо

Дээлийн оёдол сурсан юм  
Дээврийг эмжиж сураагүй юм  
Дэмжиж харж явахыг  
Дээдэл худгуй мэдээрэй  
Хамжаарыг нь оёж сурсан юм  
Ханыг нь амлуулж сураагүй юм  
Харж л дэмжиж явахыг  
Харийн худгуй мэдээрэй  
Угалзыг нь оёж сурсан юм  
Улыг нь уллаж сураагүй  
Ухаанаар дэмжиж явахыг  
Ургуйн худгуй мэдээрэй

#### Хадамд очсон хүүхний дуу

Хүрэн улаан шүрийг  
Хүндэлж юунд хадаав  
Хүүгэн бага намайгаа  
Хүнд л юунд өгөөв

Улаан хүрэн шүрийг  
Урдуур юунд хадаав

Урьхан бага намайгаа  
Уйлуулаад юунд л өгөөв  
Хавтгай мөнгөн бэлийг  
Хажууд л юунд зүүлгээв  
Хайртай бага намайгаа  
Харьд л юунд өгөөв

#### Инж хүрэн

Инж инж хүрэн  
Ижлээ дагаад үүрсэнэ  
Ижий ав хоёром  
Намайгаа гээд мэлмэрнэ  
Агсан хүрэн морь нь

#### Хүнд өгсөн хүүгэний дуу

Эрдэнэ уулын бараа  
Илхэн тод харагдана  
Ийм л ойрхон суутраа (байтлаа)  
Эргэж л буухаа яагаа юм  
Салбар салаа модонд нь  
Сайхан дуутай гургалдай

Адуугаа санаад үүрсэнэ  
Ав ижий хоёром  
Намайгаа гээд мэлмэрнэ

(жигүүртэн)  
Салаад сөөргөө харахад  
Ижий л ав минь санагдана  
Мод модны дундаас  
Мойлын иш нь илхэн  
Мордоод сөөргөө харахад  
Миний ижий илхэн

#### Аав ээжээ дурсах дуу

Энгэр ханцуй хоёр  
Элэхдээ (элэг урагдах) түргэн  
Ижий л ав л хоёр  
Энэрэхдээ түргэн  
Сарвуу ханцуй хоёр  
Салбарахдаа түргэн  
Ижий л ав л хоёр  
Санагдахдаа түргэн  
Ар л шилийн цас нь  
Алаглаа л гэж л дуулдаасай  
Ав л ижий хоёром  
Амархан (ануухан) гэж л дуулдаасай  
Энгэр шилийн цас л  
Эрээлээ л гэж дуулдаасай  
Ижий ав л хоёром  
Жүүхэн (сайн) гэж л дуулдаасай  
Алтай Хангайн даваанд  
Атан тэмээ жанжаална  
Аавыгаа гэж бодохоор алаг нүд минь мэлмэрнэ.

### Засан залан суугаарай

Дааган морийг чинь өгсөн шүү  
Дасгаж байгаад унаарай  
Даанч багад нь өглэй шүү  
Засан залаа суугаарай  
Үрээ морийг чинь өгсөн шүү  
Өсгөж байгаад унаарай  
Өнчин багад нь гаргалай шүү  
Өргөн дэмжин суугаарай  
Үйлийн ч хайшийг өгсөн шүү  
Үнэтэй торгоо эсгээрэй  
Үеийн жаахан ханьтайгаа  
Үнэнч зангаараа дасаарай  
Төрхөмийн газраас өмөөрдөг шүү  
Төвөө дарж л суугаарай  
Түргэлж яарах гэмтэй шүү  
Төвшин зангаар яваарай  
гэж 1900-аад оны үед Хөлөнбуйр баргын нутагт Гөлгөө хаван охиноо бага насанд нь харийн хошуунд бэр болгон өгөхдөө сургамжлан дуулсан гэдэг (Бадамхатан, Цэрэнханд, 2012: 143-147).

### Дүгнэлт

Барга угсаатны цагаалах, хуримлах, уул овоо тахих зэрэг олон зан үйлүүдэд тухайлсан ерөөл хэлэх, дуу дуулах уламжлалыг дамжуулан хадгалж ирсэн түүхтэй юм. Үүний зэрэгцээ тухайн зан үйлүүдээр гэр бүлийн аз жаргал, энх амгалан байх, ахмадыг хүндэтгэх, уул усаа хамгаалах зэрэг хүмүүжлийн ач холбогдол бүхий оюуны соёлын илрэлүүд харагдаж байна.

Баргуудын уламжлалт соёлын үндсэн элементүүдэд дүн шинжилгээ хийснээр тэдний уртын болон богино дууны уламжлал, хөгжлийг тоймлон үзэх бололцоотой юм. Баргуудын оюуны соёл нь монголчуудын нийтлэг ерөнхий шинжтэйгээс гадна нарийвчилсан зүйлсэд тодорхой ялгаа илүү хадгалагдаж байх ажээ. Үүний шалтгаан өөр үндэстний соёлын нөлөө гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл, Хятад, Орос, Манж болон Монголын зарим үндэстний нөлөө, ул мөр баргын соёл хоорондын харилцааг өдөөж, уламжлалт соёлын элементүүдэд нөлөөлсөн бол баргын оюуны соёл, түүний дотор уртын болон богино дуунд тийм нөлөө харьцангуй бага байж барга угсаатны гэх өвөрмөц уламжлалыг бат суурьтай болгожээ.

Барга хурим найрын дуунд ихэвчлэн уртын дуу дуулагддаг. Баргын уртын дуунд мал аж ахуй, түүхт явдал, түүхэн хүмүүс, шашин шүтлэг, үзэл баримтлал, ураг хурим, найр цэнгэл, гуниг гутрал, байгаль орчин зэргийг тал бүрээс нь тусгаж, нутаг усаа хайрлаж, настан дээдсээ хүндэтгэж, үр хүүхдээ энхрийлэн, энх амгаланг хүсэж, бүгдээр жаргахыг эрхэмлэдэг сайн сайхан сэтгэлийг өгүүлсэн байдаг. Түүнчлэн гүн ухаан, жам ёс, эрдэм мэдлэг, эрүүл энхийг эрхэмлэсэн дуу ч бий. Барга уртын дуу бол амьдрал тэмцлийн нэвтэрхий толь юм” (Уудам, 1987: 90). Хөлөнбуйрын Барга хуримын бэсрэг уртын дуу нь үе дамжин хөгжсөөр өөрийн гэсэн хэв намбатай болжээ. Нарийн гоё нугалаа чимэглэлтэй, хаялга цацлага ихтэй, төвөнх хоолойн цохилготой, дууны эхлэл чимэг ихтэйгээс гадна дуугаа ихэвчлэн хаялгаар төгсгөдөг. Цараа хүрээний хувьд Төв халхын уртын дуу шиг өргөн биш уужуу талбиун аялгуутай байдгаараа онцлогтой байдаг. Цаашид барга хуримын дуу ба барга найрын дууг ноотлон бичиж, өв уламжлалыг хамгаалах, хадгалж үлдээх, хойч үедээ үлдээх нь бидний үүрэг болно.

### Ном зүй

- Бадамхатан, С., Цэрэнханд Г,** (2012). Монголын угсаатны зүй, боть-III, Улаанбаатар: Монсудар. [Badamkhatan, S., Tserenkhand, G. Mongoliin ugsaатnii zui, boti-III, Ulaanbaatar: Monsudar. 2012.]
- Лхамсүрэн, М.** (2016). Буяндэлгэрийн намтар, ӨМӨЗО: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. [Lkhamsüren, M. Buyndelgeriin namtar, ÖMÖZO: Övör Mongoliin soyoliin khevleliin khoroo, 2010.]
- МАДЧ,** (1992). Монгол ардын дууны чуулган, ӨМӨЗО: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. [Mongol ardiin duunii chuulgan, ÖMÖZO: Övör mongoliin soyoliin khevleliin khoroo. 2012.]
- Уудам.** (1987). *Монгол хурим*, ӨМӨЗО: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. [Udam. Mongol khurim, ÖMÖZO: Övör Mongoliin soyoliin khevleliin khoroo, 1987.]
- Равдан, Д.** (2010). *Барга ардын дуу 365*, БНХАУ: Үндэстний хэвлэлийн хороо. [Ravdan, D. Barga ardiin duu 365, BNKHAU: Undestnii khevleliin khoroo, 2010.]
- Равдан, Д.** (2010). Барга ардын уртын дууны тухай өгүүлэх нь // *Дундад Улсын монгол үндэстний уртын дууны өлгий-шинэ барга зүүн хошууны ойллого 405. ӨМӨЗО: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.* [Ravdan, D. Barga ardiin urtiin duunii tukhai ögüülekh ni, ÖMÖZO: Övör Mongoliin soyoliin khevleliin khoroo, 2010.]

- Сэцэн, Г., Наранцацрал, Д. (2025). “Баргын гурван бор” уртын дуунд хийсэн шинжилгээ. *Монголын соёл урлаг судлал. Боть 26, Дугаар 50.* [Setsen, G., Narantsatsral., D. Bargiin gurvan bor, urtiin duund khiisen shinjilgee.]
- Чүлтэм. (2015). Барга газар усны нэртэй барга дуунууд, Хөлөнбуйр: Барга нүүдэлчин. [Chültem. Barga gazar usnii nertei barga duunuud, Hulunbuir: Barga nüüdelchin, 2015.]



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See:

<http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>